



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН 2020 ОНЫ XVII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XVII хурал 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 12:00 цагаас Төрийн ордны "Нээлттэй сонсголын танхим"-д 100 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН нь:

1. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхээс КОВИД-19 халдварын тархалтын нөхцөл байдал хурцдаж байгаатай холбогдуулан болзошгүй халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг шалгах дадлага сургуулилт хийх үүрэг өгсөн талаар;

*Монгол Улсын Шадар сайд,
Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин*

2. Боловсролын бүх шатны сургалтын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоосон хугацааг хичээлийн жил дуустал сунгах эсэх талаар;

*Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайд Ё.Баатарбилэг*

3. "Хилийн чанадаас эх орондоо ирэх хүсэлт гаргасан, санхүүгийн хүндрэлд орсон Монгол Улсын иргэдэд туслалцаа үзүүлэх тухай;

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар

4. БНХАУ-ын Эрээн хотод байгаа Монгол Улсын иргэдийг татан авчрах тухай;

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар

5. Нийслэлийн Хан-Уул дүүрэг дэх 300 ортой эмнэлэгийн барилгыг ашиглалтад оруулах талаар;

*Эрүүл мэндийн яамны сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл*

6. КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Нийслэлийн хороодын хэсгийн ахлагч нарт олон нийтийн цагдаагийн эрх олгох замаар хяналт, хариуцлагыг сайжруулах тухай;

*Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч,
Улсын онцгой комиссын гишүүн С.Амарсайхан*

7. Замын-Үүд боомтын өргөтгөл шинэтгэлийн ажлын талаар;

*Сангийн яамны Төрийн нарийн
бичгийн дарга С.Наранцогт*

8. КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай хуулийн төсөл боловсруулах явцын талаар;

*Ажлын хэсгийн дарга,
УИХ-ын гишүүн Ж.Энхбаяр*

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

А. КОВИД-19-ын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор бүх шатны боловсролын сургалтын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагаа (танхимын сургалт)-ыг түр зогсоосон хугацааг 2020 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл сунгах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд оруулж, шийдвэрлүүлэхээр тогтов.

Нэг. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг,
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт:

1.1. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгаар зохион байгуулж байгаа теле болон их дээд сургууль, коллежийн цахим хичээлийг 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэх;

1.2. Ерөнхий боловсролын сургуулийг төгсөгч, их, дээд сургууль, коллежид 2020-2021 оны хичээлийн жилд элсэгчдээс монгол хэл, бичгийн шалгалт авахгүй байх зохицуулалт хийх асуудлыг Засгийн газрын тогтоолын төсөлд тусгах;

Хоёр. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,
Сангийн сайд Ч.Хүрэлбаатар,
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт:

2.1. Хилийн чанадаас эх орондоо ирэх хүсэлт гаргасан, санхүүгийн тусламж нэн шаардлагатай иргэдийг тодорхойлох шалгуур, тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулах зааврыг боловсруулж, Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлэх;

Гурав. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,
Зам, тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,
Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын орлогч дарга,
хошууч генерал Т.Бадрал,
Хил хамгаалах ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,
Дорноговь аймгийн Засаг дарга,
Онцгой комиссын дарга Т.Энхтүвшин нарт:

3.1. БНХАУ-аас нутаг буцах хүсэлтэй монгол иргэдийг 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр ӨМӨЗО-ны Эрээн хотоос нэгдсэн зохион байгуулалттайгаар татан авч, ажиглалт, тусгаарлалтад авах ажиллагааг зохион байгуулах;

Дөрөв. Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал С.Баатаржав,
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч,
Улсын онцгой комиссын гишүүн С.Амарсайхан нарт:

4.1. КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, зөвлөмжийг хэрэгжүүлэх, хотын соёлыг хэвшүүлэхэд нийслэлийн хороодын хэсгийн ахлагч, бусад шалгуур хангасан иргэдэд олон нийтийн цагдаагийн эрх олгох ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах;

4.2. Нийслэлийн онцгой комиссын 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 9 дүгээр хурлын тэмдэглэлийн 6 дугаар заалтад тусгасан арга хэмжээг Засгийн газраас холбогдох шийдвэр гарсны дараагаар хэрэгжүүлж ажиллах;

Тав. Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,
Сангийн сайд Ч.Хүрэлбаатар,
Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт:

5.1. КОВИД-19-ын халдварын тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан Нийслэлийн Хан-Уул дүүрэг дэх 300 ортой эмнэлгийн барилгыг ашиглалтад оруулах бэлтгэлийг хангах хүрээнд Барилгын хөгжлийн төвийн гүйцэтгэлийн хяналтад үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2020 оны төсвийн багцад тусгагдсан 8,0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шуурхай шийдвэрлэх;

Зургаа. Зам, тээвэр хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын Д.Сумъяабазар,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү,
Өмнөговь, Дорноговь, Ховд, Сүхбаатар аймгуудын Засаг дарга,
нүүсний экспортын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагын
удирдлагад:

6.1. БНХАУ-руу авто замын хилийн боомтоор нүүрс тээвэрлэж буй аж ахуйн нэгжийн жолооч нарыг тусгай горимын дагуу тээвэрлэлтийн үйл ажиллагааг ээлж дуусмагц 14 хоног тусгаарлах байранд ажиглах, хяналт тавих, холбогдох арга хэмжээг авч ажиллах;

Долоо. Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,
Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
хошууч генерал Т.Бадрал,

7.1. КОВИД-19-ын халдвартай тэмцэх стратеги, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах бүх төрлийн нөөцийн судалгааг үндэсний хэмжээнд нарийвчлан гаргаж, Улсын онцгой комисст танилцуулах (дайчлагдах хүний нөөц, хүч хэрэгслийн болон материаллаг бааз, машин техник, барилга байгууламж, эмнэлгийн орны хүчин чадал, г.м);

7.2. КОВИД-19-ын халдвартай тэмцэх, даван туулах үндэсний чадавхыг сайжруулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор дадлага сургуулилтын бэлтгэлийг хангаж зохион байгуулах арга хэмжээ авах;

Найм. Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
хошууч генерал Т.Бадрал,
Хууль зүй, дотоод хэргийн яамны
Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн нарт:

8.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан орон нутгийн хэмжээнд хорио цээрийн дэглэмийг сахиулах, эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймаг, нийслэлийн онцгой комиссын бүрэлдэхүүнд шүүх болон прокурорын байгууллагаас төлөөлөл оруулах тухай санал боловсруулж, Улсын онцгой комисст танилцуулах;


Ес. Барилга, хот байгуулалтын сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Х.Баделхан
Сангийн сайд Ч.Хүрэлбаатар,
Дорноговь аймгийн
Засаг дарга Т.Энхтүвшинд:

9.1. Замын-Үүдийн боомтын шинэтгэлийн ажлыг гүйцэтгэх гадаад улсын мэргэжилтнүүдийг үе шаттайгаар, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулан тусгай бүсэд ажиллуулах нөхцөл боломжийг бүрдүүлж бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх;

Арав. Улсын онцгой комиссын гишүүдэд:

10.1. Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийн талаар ташаа, зөрүүтэй мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх, иргэдийн дунд төөрөгдөл, үл ойлголцол бий болгох нөхцөл үүсгэхүйц үйлдэл, мэдээлэл гаргахгүй байх, мэдээллийн нэгдмэл байдлыг хангаж ажиллах;

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Ө.ЭНХТҮВШИН

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
НАРИЙН БИЧГИЙНДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

A handwritten signature in black ink, belonging to G. Ariunbujin.

Г.АРИУНБУЯН